



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2019 оны 03 сарын 12 өдөр

Дугаар А/50

Улаанбаатар хот

Дотоод аудитын 2019 оны үйл
ажиллагааны төлөвлөгөө батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.1, 8.4 дэх хэсэг, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан “Дотоод аудитын дүрэм”ийн 7.1 дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хөдөлмөрийн дотоод журмын 5.1-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дотоод аудитын 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2.Батлагдсан төлөвлөгөөний дагуу үр дүнтэй зохион байгуулж, хэрэгжилтийг тайлагнан ажиллахыг Захиргаа, хууль зүйн хэлтэс (А.Ариунболд)-т даалгасугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Б.ГАНБАТ

Төрийн өмчийн боллого, зохицуулалтын даргын 2019 оны 2 дугаар сарын 12 ны өдрийн дугаар тушаалын хавсралт 450

Төрийн өмчийн боллого, зохицуулалтын газрын дотоод аудитын 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөө

Д/д	Аудитын ажлын дугаар	Аудитын ажлын нэр	Хамаарах нэгж, албан хаагч	Аудитын ажлын зорилго, хүрэх үр дүн	Аудит хамрах хугацаа	Аудит хийгдэх хугацаа	Харуулах хэлтэс, албан хаагч
1	ДАА2011	Төрийн өмчит үл хөдлөх хөрөнгийг шилжүүлэх үйл ажиллагааны зохицуулалтад хийх дотоод аудит	ЗХЗХ, ТӨБХХ	1. ТӨБЗГ-ын үл хөдлөх хөрөнгийг- балансаас балансад шилжүүлэх үйл ажиллагааны хууль зүйн үндэслэлд аудит хийж дүгнэлт, зөвлөмж гаргах; 2. ТӨБЗГ-ын үл хөдлөх хөрөнгийг- балансаас балансад шилжүүлэх тогтоол шийдвэрийн үндэслэл хууль, журамд нийцэх, "Төрийн өмчийн боллого, зохицуулалтын газрын хуралдааны дэг"-ийн хэрэгжилт сайжирна.	2018 оны 12-р сар дугаар сараас 2019 оны 02 дугаар сарын 26-ны өдрийг хүртэл	3 дугаар сар	Дотоод аудитын мэргэжилтэн Г.Оюунтөгөлдөр
2	ДАА2012	Дотоод аудитын дүрэм батлуулах	ЗХЗХ	1. Дотоод аудитын дүрэм батлуулах, түүнийг мөрдөж ажиллах; 2. ТӨБЗГ-ын дотоод аудитын үйл ажиллагааны дүрмийг батлуулснаар дотоод хяналт сайжирна.	Батлагдсан хугацаанаас эхлэн мөрдөн ажиллах	3 дугаар сар	Дотоод аудитын мэргэжилтэн Г.Оюунтөгөлдөр
3	ДАА2013	Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэхэд хяналт тавих	ЗХЗХ, ТӨБХХ	1. ТӨБЗГ-ын 2018 оны жилийн эцсийн аудитлагдсан санхүүгийн тайланд өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэхэд хяналт тавьж ажиллах; 2. Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэхэд хяналт, тавьж ажилласнаар Төрийн аудитын байгууллагад заасан хугацаанд нь зөвлөмжийн хэрэгжилтийг хүрүүлнэ.	2018 он	4-5 дугаар сар	Дотоод аудитын мэргэжилтэн Г.Оюунтөгөлдөр, ЗХЗХ, Ж.Мөнхтүвшин ТӨБХХ, холбогдох мэргэжилтэн
4	ДАА2014	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд заасан нутгийн өмчийн тухай хуульд заасан хугацаатай чиг үүргийн гүйцэтгэлд хийх дотоод аудит	ЗХЗХ, БТУХ, ТӨБХХ, ХААХ, МГА	1. ТӨБЗГ-аас 2018 онд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд заасан хугацаатай чиг үүргийн гүйцэтгэлд аудит хийж дүгнэлт, зөвлөмж гаргах; 2. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд заасан хугацаатай чиг үүргийн гүйцэтгэлд аудит хийснээр хуулийн хэрэгжилт сайжирч, түүнд тавих хяналт сайжирна.	2018 он	6 дугаар сар	Дотоод аудитын мэргэжилтэн Г.Оюунтөгөлдөр
5	ДАА2015	Худалдан авах ажиллагааны зохицуулалтад дотоод аудит хийх	ХААХ	1.Худалдан авах ажиллагааны зохицуулалтад аудит хийн дүгнэлт зөвлөмж гаргах; 2.Худалдан авах ажиллагааны зохицуулалтад аудит хийснээр хуулийн хэрэгжилт сайжирна.	2018 оны 06 дугаар сараас 2019 оны 06 дугаар сар хүртэл	6-12 дугаар сар	Дотоод аудитын мэргэжилтэн Г.Оюунтөгөлдөр

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дотоод аудитын 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөө (үргэлжлэл)

Д/д	Аудитын ажлын дугаар	Аудитын ажлын нэр	Хамаарах нэгж, албан хаагч	Аудитын ажлын зорилго, хүрэх үр дүн	Аудит хамрах хугацаа	Аудит хийгдэх хугацаа	Хариуцах хэлгэс, албан хаагч
6	ДАА2016	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн шилэн дансны хэрэгжилтэд хяналт тавих	ТӨБЗГ, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд	1. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн шилэн дансны хэрэгжилтэд хяналт тавин дүгнэлт, зөвлөмж гарган холбогдох албан тушаалтнуудад хүргүүлэн биелэлтийг тооцож ажиллах; 2. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн шилэн дансны хэрэгжилтэд хяналт тавьснаар хуулийн хугацаанд мэдээ, тайланг иж бүрэн байршуулж хэвшүүлэх, шилэн дансны хуулийн хэрэгжилт сайжирна.	2019 оны 06 дугаар сар, 12 дугаар сар	07 дугаар сар, дараа оны 01 дүгээр сар	Дотоод аудитын мэргэжилтэн Г.Оюунтөгөлдөр
7	ДАА2017	Дотоод аудитад байгууллагын дээд удирдлагын шийдвэрээр тухайлсан ажил үүрэг гүйцэтгэх	ЗХЗХ, БТУХ, ТӨБХХ, ХААХ, МТА	1. Байгууллагын дээд удирдлагын шийдвэрээр тухайлсан ажилд аудит хийж дүгнэлт, зөвлөмж гаргах; 2. Удирдлагаас өгсөн тухайлсан ажилд аудит хийснээр байгууллагын зорилгыг хангахад учирч байгаа болон учирч болох эрсдлээс урьдчилан сэргийлэх, хамгаалах, түүнийг илрүүлж, дээд удирдлагыг шийдвэр гаргахад мэдээллээр хангах.	2018, 2019	3-12 дугаар сар	Дотоод аудитын мэргэжилтэн Г.Оюунтөгөлдөр